



ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД  
Х.БАТТУЛГА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.05 № 1/03 ЧАГ-САГ/2014/28 /СТА-ТШЗ

**Зөрчлийг арилгах тухай**

Төрийн өмчийн хорооны 2013 оны төсвийн санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад дараах зөрчил илэрлээ.

БНХАУ-ын Засгийн газраас МУ-ын Засгийн газарт олгосон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр барьсан, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд байрлах 5235 м.кв талбай бүхий барилгыг "Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим"-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулах" 02 тоот гэрээний дагуу албан конторын зориулалтаар, ашиглалтын зардлаар эзэмшүүлэхдээ эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулаагүй байна. Дээрх гэрээг МҮХАҮТ-тай 2012 оны 3 дугаар сарын 24-ны өдөр 1 жилийн хугацаагаар байгуулж, 2014 оны 03 сарын 24-ны өдрийг хүртэл дахин 1 жилийн хугацаагаар сунгасан байна.

Гэтэл Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн хуралдааны 65 тоот тэмдэглэлд " .... уг барилгыг төрийн өмчид бүртгэн авсны дараа **МҮХАҮТ-д үнэ төлбөргүй эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Төрийн өмчийн хороо /Д.Сугар-нд даалгасан**", мөн Төрийн Өмчийн Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 473 тоот тогтоолд уг барилгыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимд эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн хорооны Тамгын газар /Л.Ганбат/-т үүрэг болгосон байхад холбогдох шийдвэрийн дагуу арга хэмжээ авч, Засгийн газраас холбогдох шийдвэр гаргуулалгүй МҮХАҮТ-д эзэмшүүлсэн байна. МҮХАҮТ нь төрийн бус байгууллага бөгөөд төрийн өмчийн уг байрыг үнэ төлбөргүйгээр ашиглаж /Уг байрны 1 жилийн түрээсийн төлбөрийг тооцвол: 5235м<sup>2</sup> x 7000 төг x12 сар= /439.7 сая төгрөг/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр .... хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-д "... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын

байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг өгч байна.

Уг барилгыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим-д эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэн биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргал, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Цогбадрах нарт хариуцуулав.

АУДИТОР



Ш.ОТГОНБАЯР